

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Данжин	Дугаар	L069
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баянтүмэн сум
Төрсөн газар	Дорнод аймаг	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хэрлэнбаяны хийд	Сүм хийдийн дугаар	ДОСР 022
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Хэрлэнбаяны хийд

- Хэрлэнбаяны хийдийн тухай та юу мэдэх вэ?

Намайг сургуульд байхад (1948) энэ Мөнхийн энгэр дээр Хэрлэнбаяны хийд байдаг байсан. Тэнд 2 жил болсон. Бас нэлээн олон ламтай, хоёр дугантай тийм хийд байсан. Тэд нар чинь хошуугаараа урдаас орж ирсэн. Тэгээд Засгийн газрын тогтоол гарч Хэрлэнбаян сум болгоод Сэргэлэн сумын наад талд төвлөрүүлсэн. Тэнд хийдээ ч бас авч очсон. Тэгээд Хөгнийнх билүү Баян-Уулынх билүү Махгал гэсэн байх аа буриад хүн. Их баян хүн. Тэр хүн 12 ханатай гэр өгч дуганыг нь босгож өгсөн гэсэн. Тэнд олон лам нартай хурал хурдаг байсан. Би хүүхэд байхдаа хичээл тараад цавын будаа ирэх гээд түүгээр гүйж л явсан.

Манайхны удам ламтай байсан айл. Миний аав ч лам байсан. Тэгээд тэнд нэг нагац ахыгаа дагуулаад арван хэдэн ямаа аваад хэдэн судартай очиж байлаа.

Тэгээд Хэрлэнбаяны хийдийг чинь Гандантай нийлүүлсэн. Галсанравжир гээд зурхайч лам очсон.

Айлууд Хэрлэнбаяны хийдэд бурхан шүтээнээ их өгсөн. Тэр их зүйлийг чинь бүгдийг дугандаа яаж дэлгэж бархав. Шүншгийг нь салгаад газарт булахыг нь бүлж байсан юм шиг байгаа юм. Сүүлд хүмүүс тэндээс бурхан их олсон.

-Хэрлэнбаяны хийдийн мяндагтан лам нар?

Чойжинжав гээд Монгол улсын алдарт уяач бий. Тэр хүний ах лам нь Мандаа гээд байсан.

-Баянтүмэн суманд ямар хийд байсан бэ?

Энэ сум чинь үхрийн бөөр шиг сум. Маш олон газраас нийлсэн. Хөгнө, Хэрлэнбаян, Ар, Өвөр Жаргалант, Баян-уул, аймгаас нийлсэн. Одоо Баянтүмэн сум гэж байна. Харин хуучин байсан хийдийг нь би мэдэхгүй.(1945 онд Өвөр Монголоос орж ирсэн үзэмчин хүн) Нутгийн хөгшчүүл Жаргалантын хүн л мэдэх байх .

-Баянтүмэн сумд бүртгэгдсэн Юмын хурал, Хүйн хурал гэдэг хоёр хурлын газрын тухай сонсож дуулсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энд баруухан Хар эрэг гэдэг газар байдаг. Тэнд намайг залуухан цэрэгт явахаас урьд тоо бүртгэгч байхад бурхан их олддог байсан. Хийд байсан юм уу, том ламын орон гэр байсан юм уу. Нэг тийм газар байдаг юм. Одоо тэнд үлдсэн юм байхгүй биз дээ.